



**СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЦОГБОЛБОРЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"Глобалтех" ХХК

БАЙРШИЛ:
Нийслэлийн Баянзүрх
дүүргийн 11-р хорооны
нутаг дэвсгэр, Богдхан
уулын ДЦГ-ын
хязгаарлалтын бүс,
Хүрхрээгийн ам

АГУУЛГА

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн хүчин чадал.....	3
1.2. 2025 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн өнөөгийн түвшин	5
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	7
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
ДӨРӨВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	17
5.1. Хөрсний чанарын мониторинг.....	17
5.2. Усны чанарын мониторинг	19
5.3. Агаарын чанарын мониторинг.....	21
ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хүрээнд хийгдсэн ажлууд.....	10
Хүснэгт 2. Хөрсний агро-хими шинж чанар.....	17
Хүснэгт 3. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	17
Хүснэгт 4. Хөрсний хүнд металлын агууламж	18
Хүснэгт 5. Хөрсний эрүүл ахуй, нянгийн шинжилгээний дүн.....	18
Хүснэгт 6. Унд ахуйн гүний худгийн усны химийн ерөнхий шинжилгээ	19
Хүснэгт 7. Унд ахуйн гүний худгийн усны эрүүл ахуйн шинжилгээний үр дүн.....	20
Хүснэгт 8. Цэвэрлэх байгууламжийн оролтын ус (бохир ус) – ны хүнд металлын шинжилгээ	20
Хүснэгт 9. Цэвэрлэх байгууламжийн оролтын ус (бохир ус) – ны химийн ерөнхий шинжилгээ	20
Хүснэгт 10. Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус (саарал ус) – ны хүнд металлын шинжилгээ	21
Хүснэгт 11. Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус (саарал ус) – ны химийн ерөнхий шинжилгээ	21
Хүснэгт 12. Агаарын чанарын шинжилгээний дүн	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Асем клабхаус.....	4
Зураг 2. Мэдээллийн самбар.....	7
Зураг 3. Гүний худгуудын тоолуур.....	8
Зураг 4. Унд, ахуйн худагт эрүүл ахуйн бүс тогтоож хашаажуулсан байдал	8
Зураг 5. Төслийн талбай дахь засварын төв, аж ахуйн хашаа	9
Зураг 6. Суулгацын хүлэмжин дэх ургалт ба талбайд тарихын өмнөх үе	11
Зураг 7. Суулгац тарих нүх бэлтгэж буй байдал.....	11
Зураг 8. Суулгацуудыг нүхэнд суулгаж буй байдал.....	11
Зураг 9. 2 настай шинэсийн тарьц, суулгацыг суулгасны дараах байдал.....	12
Зураг 10. Усалгааны төв шугам ба түүнээс салаалуулж буй байдал, шугамын хаалт	12
Зураг 11. Усалгааны системийн талбайд харагдах байдал.....	13
Зураг 12. Спорт, аялал жуулчлалын цогцолбор орчмын ургамалжилт	13
Зураг 13. Хаягдал бор цаасан хайрцгийг ялгаж дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлэх үйл явцаас.....	14
Зураг 14. Ангилан ялгах савнууд.....	14
Зураг 15. Бүх ажилчдыг хамруулсан орчны цэвэрлэгээний ажлын явцаас	15
Зураг 16. Цэвэрлэх байгууламж	16

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн хүчин чадал

“Спорт, аялал жуулчлалын цогцолбор” нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэр, Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд, Хүрхрээгийн амны 125934м² (12.5934 га) талбайд үйл ажиллагаа явуулж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах гэрээг 2023.05.23-ны өдөр шинэчлэн байгуулсан бөгөөд 2028 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүчинтэй.

Нэг дор 1300 хүнд, өдөрт 4000 хүнд үйлчлэх хүчин чадал бүхий лифт, уулын цана, снөүбоард, гүйлтийн цана, чарганы зам талбайтай, 300 хүн хүлээн авах чадалтай ресторан, уулзалтын өрөө, спа бүхий клубхаусын барилга, асем гэр ресторан, скай эвент холл, хүн театр, 10 ширхэг гэртэй амралт, ажилчдын оффис, засварын төв, граж, 1000 автомашины зогсоол болон цанын бүх төрлийн хэрэгсэл худалдаалах, түрээслэх үйлчилгээний төв, бохир ус цэвэршүүлэх байгууламж (120 м³/хон), хиймэл нуурууд гэсэн үндсэн барилга байгууламжуудаас бүрдэнэ. Түүнчлэн нийт 7140 м урттай цанын 10 замтай. Үүнд:

- Анхлан суралцагчийн зам 110 м ба газраар урсдаг 2 хос 45 квт чадлын лифтээр тоноглогдсон /Хурхын зам/
- Анхан болон дунд шатны 4 замын урт 2260 м /Нүхт, Чулуут, Тэнгэр, Арцатын зам/
- Дунд болон мэргэжлийн шатны 3 замын урт 3140 м /Хүрхрээ, Зайсан, Залаатын зам/
- Чарганы зам 130 м, урсдаг лифтээр тоноглогдсон ба 100-120 хүнд үйлчлэх чадалтай /Богинын зам/
- Гүйлтийн зам нь 1500 м урттай.

Дээрх замууд нь шөнийн гулгалт хийх зориулалт бүхий 156 хос гэрэлтүүлэгтэй. Хүүхэд болон том хүний 1800 ширхэг цанын нөөцтэйгээр үйлчилдэг. Цанын баазын үйл ажиллагаа нь жил бүрийн 11-р сарын дунд үеэс 3-р сарын сүүл хүртэлх хугацаанд үргэлжилдэг. Жилдээ 100 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын цасны баяр болон цана, гүйлтийн цана, биатлон, снөүбоардын нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулдаг. Харин бусад үйлчилгээ нь жилийн 4 улирлын турш үйл ажиллагаа явуулдаг.

Дүүжин замын лифт нь 198квт чадалтай, 260 суудалтай тус бүр 1050 болон 900 м урттай 2 хэсгээс бүрдэнэ. Анхан шат ба чарганы урсдаг лифт нь 45квт чадалтай 3 ш лифтнээс бүрдэнэ. Энэхүү тоног төхөөрөмж болон бусад барилга объектүүд нь аюулгүй ажиллагааны нөөц 800 кВт чадлын бүрэн автомат системтэй дизель генераторт холбогдсон.

Асем клубхаус, ски эвент холл, гэр ресторанууд нь бүх төрлийн босоо болон суугаа хүлээн авалт, хурим найр, эвент, байгууллагын арга хэмжээ зохион байгуулах зориулалттай орчин үеийн шийдэл бүхий тав тухтай, тансаг орчныг бүрдүүлсэн байна. Клубхаус нь ресторан, саун, жакузи, хурал уулзалтын тусгайлан бэлтгэсэн өрөөнүүдээс бүрддэг.

Ски эвент холл нь 500 хүний багтаамжтай бөгөөд мэргэжлийн түвшний тайз, хөгжим, гэрэлтүүлэг зэргээр бүрэн тоноглогдсон, гадна террас, шилэн гарден болон дотор зааландаа зочид хүлээн авдаг.

Асем гэр нь монголын уламжлалт ахуй соёлыг харуулсан, өвөрмөц тансаг хийцтэй бөгөөд суугаа 150 хүртэл, босоо 350 хүртэлх хүнийг хүлээн авах боломжтой. Зуны улиралд олон улсын уулзалт чуулган, хурал, хүлээн авалт зэрэг арга хэмжээ зохион байгуулдаг, гадна дотны жуулчид аялагчдад зориулсан хүлээн авалтын заалтай.

"Хүн театр" нь Монгол үндэсний язгуур урлаг, соёлын баялаг өв, орчин үеийн технологийн дэвшлийг хослуулсан бүх төрлийн тоглолт, корпорацийн хүлээн авалт, концерт, театр зэрэг үзвэр үйлчилгээ үзүүлэх зориулалттай. Нийт 280 хүний багтаамжтай бөгөөд стандартын шаардлага хангасан агааржуулалтын систем, мэргэжлийн дуу, гэрэлтүүлэг, ариун цэврийн өрөө зэргээр бүрэн тоноглогдсон. Жилийн 4 улирлын турш үйл ажиллагаа явуулдаг.

Монгол гэрийг орчин үеийн хэв маягтай хослуулан 10 ширхэг гэр кэмпиог байгуулан ажиллуулж байна. Гэр кэмп нь нийт 20-30 хүний хүчин чадалтай. Нэг гэрт ойролцоогоор 2-3 хүн байрлах боломжтой. Гэрүүдийг шалны халаалтаар халаадаг. Улаанбаатар хотын цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон тул ариун цэврийн асуудлыг гэр дотроо шийдвэрлэсэн. Гэр кемпэд зөвхөн дулааны улиралд зочид хүлээж авдаг.



Зураг 1. Асем клубхаус

1.2. 2025 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн өнөөгийн түвшин

Компаний бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн түвшин 2025 оны 10 дугаар сарын байдлаар 86 хувьтай байна.

Зорилт	Стратеги /Хийгдэх ажил	Хэмжүүр	Гүйцэтгэлийн % (2025 оны 10 сарын байдлаар)
I. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ			90%
Маркетингийн үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	Байгууллагын борлуулалтыг өсгөх	Байгууллагын борлуулалтын төлөвлөгөө 100%	90%
	Сошиал суваг идэвхжүүлэлтийг өсгөх	Дагагчийн тоо 40% өсгөх	90%
Рестораны борлуулалтыг нэмэгдүүлэх	Меню шинэчлэх, хоолны сонголтыг нэмэгдүүлэх	Борлуулалтын төлөвлөгөө 100% (1,828,281,495)	90%
Snow playing area	Гадна дотор талбайн тохижилт	Ажлын төлөвлөгөө 100%	хугацаа болоогүй
Маркетингийн үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	Гольфын спортыг олон нийтэд сурталчлах замаар үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх	Үйлчлүүлэгчийн тоо 12,233 Хувь 10%	75%
Бэлтгэл сургуулилтыг хийх таатай нөхцөл байдлыг бүрдүүлэх Гольф реинж ажиллах цагийг уртасгах	Гадна талбайн өнгө үзэмж, тохижилт сайжруулах тохижуулах, тоног төхөөрөмж сайжруулах	Ажлын төлөвлөгөө 100 %	85%
Хүлээн авалтыг дэмжсэн нэмэлт хөтөлбөрүүд	Хөгжмийн фестиваль зохион байгуулах	Ажлын төлөвлөгөө 100 %	100%
Хүлээн авалтын орчноо сайжруулах	Тохижилт засварын ажил	Ажлын төлөвлөгөө 100 %	100%
Рестораны борлуулалтыг нэмэгдүүлэх	Меню шинэчлэх, хоолны сонголтыг нэмэгдүүлэх	Борлуулалтын төлөвлөгөө 100% (6.442.702.199)	90%
Pro shop-ын үйл ажиллагааг идэвхижүүлэх		Борлуулалтын төлөвлөгөө 100% (100,076,350)	75%
II. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ			75%
Бэртэл гэмтлийг бууруулах	Цанын сургалтын үйл ажиллагааг дэмжих, Анхан шатны сургалт зохион байгуулах	Бэртэл гэмтлийн тоо ... Хувиар багасах	100%
Үйлчлүүлэхэд таатай орчин нөхцөл бүрдүүлэх	Тохижилт сайжруулалт хийх	Ажлын төлөвлөгөө 100 %	50%
III. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ САЙЖРУУЛАХ, АЖИЛЛАГСДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ			91%
OCS нэмэгдүүлэх	Албан бүр OCS сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2025 оны судалгааны үр дүн 88%	100%
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажиллах таатай орчин, нөхцлийг бүрдүүлнэ	ISO 9001:2015 тогтолцоог нэвтрүүлэх	Хэрэгжүүлж нэвтрүүлсэн байх	80%
Сургалт, хөгжлийн	2025 оны дотоод, болон	Төсвийн гүйцэтгэл,	90%

төсөв, төлөвлөгөө гаргах	гадаад сургалтын төсөв, төлөвлөгөө батлан, хэрэгжүүлэх	төлөвлөгөө 100%	
Ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх	Олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах	Ажлын төлөвлөгөө 100%	90%
	Ажилтанд өгөх үнэ цэнэ батлуулах, хэрэгжүүлэх	Turnover rate 45 % барих	100%
Ажилтны ажиллах аюулгүй орчинг бүрдүүлэх	Тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчлэх, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах засвар үйлчилгээг хийх үзлэг хяналтыг тогтмолжуулах, баримтжуулах	Цахилгаан эрчим хүчний аудит үнэлгээний дүгнэлт 80%+	85%
IV. FDA, АУДИТ ҮНЭЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ			90%
HR FDA 2025	Хүний нөөцийн чиг үүргийг хууль дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэх	MCSH FDA үнэлгээ 90%+	90%
Хууль, нийцлийн менежментийг хэрэгжүүлэх	Хууль нийцлийн эрсдэлийг бууруулах	Аудитын үнэлгээ 85%+	90%
Эрсдэлийн менежментийн тогтолцоог нэмэгдүүлэх	Үнэлгээг ахиулах, хэрэгжилтийг хангуулах	Аудитын үнэлгээ 85%+	90%
Худалдан авалтын FDA	Үнэлгээг ахиулах, хэрэгжилтийг хангуулах	Аудитын үнэлгээ 85%+	90%
ХАБЭА-н эрсдэлийг бууруулах	ХАБЭА багц журам батлуулж, хэрэгжүүлэх	Аудитын үнэлгээ 85%+	90%
Гүйцэтгэлийн дундаж			86%

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө нь доорх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно. Үүнд:

- Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлж, амрагч, аялагчдад анхааруулах замаар цогцолборын орчны гадаргын усан сүлжээг бохирдохоос сэргийлэх;
- Гадаргын болон газрын доорх усны ашиглалттай холбоотойгоор холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл дүгнэлт авч, эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулах;
- Гүний худгуудын тоолуурыг баталгаажуулснаар ус ашиглалтанд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;
- Агаарын чанарт сөрөг нөлөөлж болзошгүй нөхцөлийг урьдчилан хянах зэрэг болно.

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОРЧНЫ ХҮРХРЭЭГИЙН ГОЛ ДАГУУ АЯЛАГЧ АМРАГЧДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХҮЙЦ, ГАДАРГЫН УС БОХИРДУУЛАХААС СЭРГИЙЛСЭН АНХААРУУЛАХ САМБАР БАЙРШУУЛАХ

Төслийн талбай нь хотын төвтэй ойр байршилтай, унаган төрхөө хадгалан үлдсэн үзэсгэлэнт байгальтай, өвөл зуны аль ч улиралд амарч зугаалахаас гадна спортоор хичээллэн цагийг боловсон өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг давуу талуудтай учраас үйлчлүүлэгчид ихээр зорьж ирдэг. Иймд төслийн талбайн орчны гадаргын усыг бохирдож доройтохоос сэргийлэх, цогцолбороор үйлчлүүлж буй иргэдэд гадаргын усны хамгаалалтын бүс, мөрдөх дэглэмийн талаар мэдээлэл хүргэх зорилгоор талбайн голоор урсах Туул голын орчимд доорх анхааруулах, мэдээлэл хүргэх санамж бүхий самбаруудыг байршуулсан.



Зураг 2. Мэдээллийн самбар

2. ГҮНИЙ ХУДГУУДЫН ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙЛГЭХ

“Спорт, аялал жуулчлалын цогцолбор” төслийн унд ахуй болон технологийн ус хэрэглээг гүний худгаар хангадаг. Технологийн ус хэрэглээ нь хиймэл цас үүсгэхэд зарцуулагдах ба жилд нэг удаа 11-12-р сарын дунд үе хүртэлх хугацаанд 20-30 см гүнтэй, 35000 м³ орчим цас үүсгэдэг. Унд ахуйн зориулалтаар хоногт 30.9 м³, жилд 11028 м³ ус хэрэглэдэг. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 дүгээр сарын 16-ны өдрийн А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу төслийн ус хэрэглээг хангаж буй гүний худгуудын тоолуурын баталгаажуулалтыг хийлгэж гэрчилгээ авсан. Баталгаажуулалтын гэрчилгээг хавсаргав (Хавсралт 1).

- 1-р гүний худгийн тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээний дугаар: 265623, хүчинтэй хугацаа: 2027 оны 08 дугаар сарын 12-ны өдөр хүртэл
- 2-р гүний худгийн тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээний дугаар: 244231, хүчинтэй хугацаа: 2027 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл



Зураг 3. Гүний худгуудын тоолуур

Унд ахуйн ус хэрэглээг хангаж буй гүний худагт эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалалтын хашаа хийсэн.



Зураг 4. Унд, ахуйн худагт эрүүл ахуйн бүс тогтоож хашаажуулсан байдал

3. УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 28.4-Т ЗААСНЫ ДАГУУ УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААР “УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ”

ГАРГУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ АВЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛЛАХ, УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ТӨЛӨХ

Ус ашиглуулах дүгнэлтийг ЗГХА Усны газраар 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр гаргуулсан. Дүгнэлтээр унд ахуй болон технологийн зориулалтаар 2025 онд 159802м³ ус хэрэглэх тооцоо гарсан байна (Хавсралт 2).

Ус ашиглуулах дүгнэлтэнд үндэслэн ус ашиглах гэрээг 2025 оны 06 дугаар сард Туул голын сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээний дугаар: 25/25 SR-OP-25-033, Хүчинтэй хугацаа: 1жил (Хавсралт 3).

Ус ашиглах гэрээнд 2025 оны усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, 27'147'998.04 төгрөгийг төсөвт төвлөрүүлэх тухай тусгасан байна. Гэрээний дагуу 2025 оны 1-9 дүгээр сар хүртэлх хугацааны ус ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд төлбөрийг сар бүр тогтмол төлж хэвшсэн болно. Мөн ЗГХА Усны газраар 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хаягдал усны дүгнэлт (Дугаар: E-2505-000207) гаргуулсан. Дүгнэлтээр гарсан ус бохирдуулсны төлбөр болох 981'730.05 төгрөгийг төлсөн (Хавсралт 4).

4. ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААГ “ГАЗРЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ДАГУУ 5 ЖИЛ ТУТАМД 1 УДАА ХИЙЛГЭХ

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайланг 2025 оны 6 дугаар сард газрын мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт нь баталгаажсан. Хянан баталгааны тайлангийн баталгаажсан дүгнэлтүүдийг хавсаргав (Хавсралт 5).

5. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БУЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, МАШИН МЕХАНИЗМУУДЫГ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛЖ, ХӨДӨЛГҮҮРИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА ДУУССАН БОЛОН ДУТУУ ШАТАЛТ ҮҮСГЭН ХОРТ УТАА ЯЛГАРУУЛЖ БУЙ ТЕХНИКИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙХ, ШААРДЛАГАТАЙ ҮЕД ХАЯГДАЛ УТААГ ШҮҮХ ШҮҮЛТҮҮР, КАТАЛИЗАТОР ХЭРЭГЛЭХ

Төслийн үйл ажиллагааны үед ашиглаж буй машин механизм, тээврийн хэрэгслүүдийг жил бүр техникийн үзлэг оношилгоонд хамруулж шаардлагатай засвар үйлчилгээг өөрсдийн засварын төвд хийдэг. Мөн техник тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, түр хугацаанд ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмж техник хэрэгслүүдийг аж ахуйн хашаанд түр хадгалдаг. Техникийн үзлэгээр агаарт хорт хий ихээр ялгаруулж буй болон эвдрэл гэмтэл ихтэй машин механизм, тээврийн хэрэгслүүдийг компаний дотоод журмын дагуу акталдаг. 2025 онд ашиглалтаас гарсан тээврийн хэрэгсэл, машин механизм байхгүй байна. Тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт хамруулсан тухай баримтыг хавсаргав (Хавсралт 6). Техникийн үзлэгээр хөдөлгүүрийн шаталтаас агаарт ялгаруулж буй хийн төлөвт бохирдуулагч нь хэвийн түвшинд байсан болно.



Зураг 5. Төслийн талбай дахь засварын төв, аж ахуйн хашаа

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Глобалтех” ХХК нь БОАЖЯ-тай 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 2023/015 дугаар бүхий “БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАРТ ГАЗАРТ МОД ТАРИХ АЖЛЫН ГЭРЭЭ”-г байгуулсан. Уг гэрээ нь аялал жуулчлалын зориулалтаар ашиглах зөвшөөрөл бүхий талбайн орчны хязгаарлалтын бүс дэх 183.1 га газарт байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр мод тарьж, байгаль хамгаалах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих ажилд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой бөгөөд нийт 163160 ширхэг навчит болон шилмүүст моддыг (шинэс, нарс, долоогоно, монос, хайлаас, шар хуайс, улиас, гүйлс) 3 жилийн хугацаанд тарих үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд 2025 онд дээрх гэрээний хавсралтанд тусгасан 4.5 га талбайд 2000 ширхэг шинэсийн 2 настай суулгац тарихаар төлөвлөсөн.

Төлөвлөгөөний дагуу ойжуулах, мод тарих ажил нь мод тарих талбай, нүхийг урьдчилж бэлтгэх, 2 настай шинэс модны суулгац худалдан авах, усалгааны систем бэлтгэх, хаврын тариалалт хийх, байнгын усалгаа арчилгаа гэсэн үе шаттайгаар хийгдсэн.

Хүснэгт 1. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хүрээнд хийгдсэн ажлууд

№	Ажлын төрөл	Хэмжээ	Гүйцэтгэх хугацаа
1	Мод тарих талбайг бэлтгэх	4.5 га	5 дугаар сар
2	Хавар тариалах шинэс модны суулгац худалдан авах	2000 ширхэг	5 дугаар сар
3	Усалгааны систем хийх	2 ширхэг 5 тн-ны сав, 3000 м дуслын усалгааны систем	4-5 дугаар сар
4	Усалгаа, арчилгаа	Мод сөөгний усалгааг тухайн тарьсан сард 4 удаа, дараагийн сараас эхлэн сард 2-3 удаа, хавар намрын цэнэг усалгааг 3, 10-р саруудад тус бүр нэг удаа, нийт нэг жилд 21 удаагийн давтамжтай усалгаа хийнэ.	5-10 дугаар сард тогтмол
5	Намар тооллого хийх	Ургалтын хувийг баримтжуулах	11 дүгээр сар
6	Тарьсан модыг өвөлд бэлтгэх	Цасаар хучих	11 дүгээр сар

Бид Сэлэнгэ аймгийн Шаамар суманд байрлах “Мандан баясах” ХХК-ийн бэлтгэн гаргасан “Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага MNS 6140:2010” стандартын шаардлага хангасан 1-р зэргийн суулгацыг худалдаж авсан. Уг суулгац нь үрээр тарьж, бойжуулгын талбайд шижлүүлэн суулгаж ургуулсан 2-3 настай шинэс модны суулгац байв (Зураг 6).

Тарилтыг 5 дугаар сарын дунд үед хийж гүйцэтгэсэн бөгөөд компаний ажилчдыг хамруулсан.



Зураг 6. Суулгацын хүлэмжин дэх ургалт ба талбайд тарихын өмнөх үе



Зураг 7. Суулгац тарих нүх бэлтгэж буй байдал



Зураг 8. Суулгацуудыг нүхэнд суулгаж буй байдал




Зураг 9. 2 настай шинэсийн тарьц, суулгацыг суулгасны дараах байдал

Тарьсан мод сөөгийг услах нь түүний өсөлт хөгжилт ба амьдралтыг дээшлүүлэх үндсэн арга байдаг. Хур бороо багатай, хуурайшилттай үед шинээр тарьсан модыг заавал тогтмол услах шаардлагатай. Бид БОАЖЯ-тай байгуулсан “БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАРТ ГАЗАРТ МОД ТАРИХ АЖЛЫН ГЭРЭЭ”-ний үүргээ биелүүлж жил бүр мод тарих ажлыг хийх болсон тул өөрсдийн инженерийн багийг ажиллуулан шинээр тарьсан моддыг услах усалгааны иж бүрэн системийг суурилуулсан. Усалгааны системийг суурилуулахдаа үндсэн гол шугамыг Ф-16 мм² хөндлөн огтлолтой HDPE уян шугам хоолойгоор 21000 м урттайгаар татаж, бусад дагалдах холбох хэрэгслүүдээр холбож, салбар шугам бүр дээр хаалт байршуулан 3 хэсэгт хувааж усалгаа хийж байна. Усалгааны систем нь хоногт 38.7 м³ буюу сард нийтдээ 1549 м³ ус зарцуулахаар тохиргоо хийгдсэн. Энэ дуслын усалгааны шугамаар одоо тарьсан моддыг болон цаашид тарихаар төлөвлөсөн нийт моддыг услах бүрэн боломжтой.



Зураг 10. Усалгааны төв шугам ба түүнээс салаалуулж буй байдал, шугамын хаалт



Зураг 11. Усалгааны системийн талбайд харагдах байдал



Зураг 12. Спорт, аялал жуулчлалын цогцолбор орчмын ургамалжилт

Бид Ойн тухай хуулийн 14.3.20-д заасны дагуу 2025 онд тарьсан моддыг ойн санд тоолон хүлээлгэн өгөх хүсэлтээ ЗГХА Ойн газарт өгсөн боловч Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А96/71 дүгээр тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг улсын худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 5.8.2 дахь заалтын дагуу 5-аас дээш жил арчилж ургуулсан, 8 ба түүнээс дээш настай байх шалгуур үзүүлэлтийг хангасны дараа ойн санд хүлээлгэн өгөх боломжтой гэсэн хариу ирсэн болно.

ДӨРӨВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Спорт, аялал жуулчлалын цогцолбор” төслийн 2025 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар хаягдлын менежментийг сайжруулах, орчны хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн цэвэрлэгээг нийт ажилчдын дунд зохион байгуулж, ил задгай хог хаяхгүй байхыг нийт ажилчид болон нийгэмд уриалах, зөв үлгэрлэл бий болгоход чиглэгдсэн.

Ахуйн хаягдлыг одоогийн байдлаар 100 м² талбай бүхий хатуу хаягдлын цэгт түр хуримтлуулан “ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ” – ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү тээвэрлэж байна. Хог хаягдал тээвэрлэх, цуглуулах үйлчилгээний гэрээг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн байгуулсан. Гэрээний үргэлжлэх хугацаа 1 жил (Хавсралт 7). Үйл ажиллагааны үед хуримтлагдсан хаягдлыг богино хугацаанд тогтмол тээвэрлэж хур хог үүсгэхгүй байх тал дээр байнга анхаарч ажилладаг.

Мөн хуванцар сав, гялгар уут, цаасан хайрцаг, лааз гэх мэт дахин боловсруулах боломжтой хаягдлыг ангилан ялгаж иргэн Д.Даваасүрэнтэй байгуулсан даалгаврын гэрээ (Хавсралт 8) – ний дагуу дахин боловсруулах үйлдвэр, дахивар нөөцийн цэгүүдэд нийлүүлэх арга хэмжээ авч ажилладаг. Үйлчилгээний барилга байгууламжийн дотор болон гадна ангилан ялгах хогийн савнуудыг байршуулсан.



Зураг 13. Хаягдал бор цаасан хайрцгийг ялгаж дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлэх үйл явцаас



Зураг 14. Ангилан ялгах савнууд

Түүнчлэн “Цэвэр агаар, цэмцгэр орчин” уриан дор байгууллагынхаа нийт ажилчдыг хамруулсан бүх нийтийн цэвэрлэгээг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж, аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж, үйл ажиллагаа явуулж буй нийт талбайгаа 8 хэсэгт хуваан, талбайн хуваарилалт хийж орчноо цэвэрлэсэн. Бүх нийтийн цэвэрлэгээ хийх талбайд нийт ажилчдыг хуваарилсан хуваарилалт, заавар зөвлөгөө бүхий удирдамжийг удирдлагын түвшинд батлуулж, цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн болно. Уг удирдамжийг тайланд хавсаргасан (Хавсралт 9) бөгөөд ажлын явцыг доорх зургуудад харуулав.



Зураг 15. Бүх ажилчдыг хамруулсан орчны цэвэрлэгээний ажлын явцаас

Цогцолборын барилга байгууламжууд тэр дундаа ресторан, үйлчилгээний төвүүд, ажилчдын оффисоос гарах ахуйн шингэн хаягдал буюу бохир усыг 120 м³/хон-ийн хүчин чадалтай өөрийн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлдэг. Цэвэрлэгдсэн саарал усыг хиймэл нууранд хуримтлуулж, зэргэлдээх гольфийн талбайн усалгаа хийдэг. Цэвэрлэх байгууламжийн технологид химийн бодис хэрэглэдэггүй. Технологийн процессийг товч дурдвал:

1. **Анхдагч тунгаагуур:** Бохир ус байгууламж руу ороход түүхий бодисууд болон лаг доош сууна. Механикаар цэвэрлэгдсэн ус биологийн цэвэрлэгээний шат руу шилжинэ.
2. **Биологийн цэвэрлэгээ:** Дотор хэсэгт микро биетүүд амьдрах, тээвэрлэгч материалууд байх ба тэдгээрийн тусламжтайгаар хорт бодисыг 99% хүртэл устгах чадалтай өндөр түвшний биофилмийг үүсгэнэ.
3. **Агааржуулалт:** Биологийн цэвэрлэгээний шат нь микро биетүүд хорт бодисыг устгахад шаардагдах агаараар буюу хүчилтөрөгчөөр хангагдана.
4. **Хоёрдогч тунгаагуур:** Биологийн цэвэрлэгээнээс гарсан хатуу бодисууд шаланд тунаж үлдэнэ.
5. **Лэг цэвэрлэх:** Хоёрдогч тунгаагуураас лагийн үлдэгдлийг зайлуулна.
6. **Гаралт:** Цэвэрлэгдсэн ус дээж авах хэсгээр дамжин хиймэл усан санд нийлнэ.



Зураг 16. Цэвэрлэх байгууламж

ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ашиглах зөвшөөрөл бүхий талбайн хөрс, газрын доорх уснаас дээж авч хөрс, усны итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлэх, орчны агаарын чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор газар дээр нь шинжлүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэсэн бөгөөд хяналт шинжилгээний үр дүнг тайланд хавсаргасан болно.

5.1. Хөрсний чанарын мониторинг

Хөрсний чанарын мониторингийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ашиглах зөвшөөрөл бүхий 4 нэгж талбарын 8 цэгээс 0-20 см гүнтэй өнгөн зүсэлт хийж, нийт 8 ширхэг дээж авч агрохими, хүнд металл болон нянгийн бохирдол тодорхойлох хяналт шинжилгээг “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн.

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд хөрсний үржил шимийг илтгэгч үзүүлэлт болох ялзмагийн агууламж нь газар ашиглалтын нөлөөлөлд хамгийн ихээр өртсөн авто зогсоол, барилга байгууламж орчмын хөрсний өнгөн хэсэгт буюу 0-20 см-ийн гүнд 0.21-0.38% буюу маш бага, бусад хэсгүүд болох хиймэл нуур ногоон байгууламж бүхий хэсгүүдэд 1.13-3.06% буюу дунд зэрэг байна.

Урвалын орчин нь 7.93-9.06 буюу дундаас хүчтэй шүлтлэг байгаа нь органик агууламж их байгаатай холбоотой. Хөрсний хялбар уусах давсжилт нь бага буюу сул давсархаг, ургамлын өсөл хөгжилтөнд хамгийн чухал нөлөө үзүүлдэг шим тэжээлийн макро элементүүд болох хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар сайн байна (Хүснэгт 2). Харин хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр, дунд болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 2. Хөрсний агро-хими шинж чанар

НТД	Лаб №	Дээж авсан гүн, см	рН	Давс	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	NO ₃ мг/100г	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1333108677	25/4398	0-20	8.40	0.05	0.101	1.13	0.59	0.00	8.1	2.9	1.4	13
1333108792	25/4397	0-20	8.24	0.07	0.157	2.16	0.67	0.00	12.2	4.9	2.8	28
1333108796	25/4396	0-20	8.26	0.08	0.170	2.58	0.75	0.00	17.2	8	3.2	9
1333112766	25/4391	0-20	8.77	0.11	0.238	0.38	0.51	3.13	10.58	5.3	2.2	73
	25/4392	0-20	9.06	0.13	0.260	0.21	0.43	2.14	10.36	5.8	1.5	42
	25/4393	0-20	8.34	0.10	0.208	3.06	0.76	0.32	17.12	7.9	3.5	37
	25/4394	0-20	8.78	0.09	0.187	2.83	0.81	0.82	10.42	7.5	3.2	30
	25/4395	0-20	7.93	0.06	0.122	2.92	0.78	0.00	10.6	4.8	3.1	32

НТД-Нэгж талбарын дугаар

Хүснэгт 3. Хөрсний механик бүрэлдэхүүн

НТД	Лаб №	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд (%), ширхэгийн хэмжээ (мм)							Механик бүрэлдэхүүний нэр
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
1333108677	25/4398	0-20	42.3	32.9	10.7	0.4	6.6	6.9	14.0	Элсэнцэр
1333108792	25/4397	0-20	23.2	28.9	11.6	20.6	7.9	7.8	36.3	Дунд шавранцар

1333108796	25/4396	0-20	27.3	43.3	14.0	6.7	2.7	6.0	15.4	Элсэнцэр
1333112766	25/4391	0-20	32.9	34.0	14.6	3.0	9.5	6.1	18.5	Элсэнцэр
	25/4392	0-20	4.5	41.4	26.5	4.0	17.3	6.3	27.6	Хөнгөн шавранцар
	25/4393	0-20	13.7	39.3	20.4	8.2	9.0	9.3	26.6	Хөнгөн шавранцар
	25/4394	0-20	16.1	38.7	21.0	3.5	10.3	10.4	24.2	Хөнгөн шавранцар
	25/4395	0-20	16.3	41.0	22.4	8.5	6.1	5.6	20.2	Хөнгөн шавранцар

Түүнчлэн дээрх 8 цэгээс хүнд металлын дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэсэн. Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см^3 -ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм. Шинжилгээгээр Зэс (Cu), Хром (Cr), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цайр (Zn), кадми (Cd) гэсэн 6 элементүүдийг тодорхойлж, MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд агууламжтай харьцуулахад хүлцэх агууламжаас даруй хэд дахин бага буюу хүнд металлын бохирдол илрээгүй болно (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хөрсний хүнд металлын агууламж

№	НТД	Лаб №	Дээж авсан гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni	Cd	Pb	Cu	Zn	Cr
1	1333108677	25/4398	0-20	8.56	ND	12.79	11.91	66.29	ND
2	1333108792	25/4397	0-20	17.87	ND	17.45	18.3	71.45	3.81
3	1333108796	25/4396	0-20	24.73	ND	12.5	20.19	60.26	8.08
4	1333112766	25/4391	0-20	10.18	ND	24.56	5.8	63.36	ND
5		25/4392	0-20	23.31	ND	13.79	25.52	57.44	6.16
6		25/4393	0-20	23.01	ND	18.49	27.52	63.36	10.74
7		25/4394	0-20	21.12	ND	16.5	23.43	59.41	6.45
8		25/4395	0-20	17.71	ND	14.84	19.71	55.36	5.54
Хүлцэх агууламж / MNS 5850:2019/				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS:5850:2019/				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнгээс үзэхэд нянгийн тоо, гэдэсний савханцарын таньц, перфрингенсийн таньц зэрэг үзүүлэлтүүд нь цэвэр гарсан байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Хөрсний эрүүл ахуй, нянгийн шинжилгээний дүн

№	НТД	Лаб №	Хариу		Лавлах хэмжээ
1	1333108677	25/4398	Нянгийн нийт тоо	$5.2 \cdot 10^5$	-
			E.Coli	0.01	≥ 0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥ 0.1	≥ 0.1
2	1333108792	25/4397	Нянгийн нийт тоо	$4.9 \cdot 10^5$	-
			E.Coli	0.01	≥ 0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй

			Cl.perfringens	≥0.1	≥0.1
3	1333108796	25/4396	Нянгийн нийт тоо	6.2*10 ⁵	-
			E.Coli	≥0.1	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1
4		25/4394	Нянгийн нийт тоо	6.9*10 ⁵	-
			E.Coli	0.01	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1
5		25/4395	Нянгийн нийт тоо	7.9*10 ⁵	-
			E.Coli	0.01	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1
6	1333112766	25/4393	Нянгийн нийт тоо	5.1*10 ⁵	-
			E.Coli	≥0.1	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1
7		25/4392	Нянгийн нийт тоо	4.3*10 ⁵	-
			E.Coli	≥0.1	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1
8		25/4391	Нянгийн нийт тоо	4.8*10 ⁵	-
			E.Coli	0.01	≥0.1
			Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
			Cl.perfringens	≥0.1	≥0.1

5.2. Усны чанарын мониторинг

Цогцолборын унд ахуйн ус хэрэглээг хангаж буй гүний худгаас дээж авч химийн ерөнхий болон эрүүл ахуйн шинжилгээг 2025 оны 1 дүгээр сард хийлгэв. Шинжилгээний үр дүнг доорх хүснэгтээр харуулав.

Гүний худгийн усны шинжилгээний үр дүнгээс үзэхэд урвалын орчин буюу pH нь стандарт хэмжээнээс бага буюу дунд зэрэг хүчиллэг байна. Бусад химийн ерөнхий болон эрүүл ахуйн үзүүлэлтүүд нь MNS0900:2018 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээний хүрээнд байна (Хүснэгт 6, 7).

Хүснэгт 6. Унд ахуйн гүний худгийн усны химийн ерөнхий шинжилгээ

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	Үр дүн	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS0900:2018
1	pH-Усан орчин /Hydrogen ions/	5.57	6.5-8.5
2	Цахилгаан дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	0.09	<1.0
3	Карбонат (CO ₃ ²⁻), мг/л /Carbonate ion, mg/L/	0.00	-
4	Гидрокарбонат (HCO ₃ ⁻), мг/л /Hydrocarbon ion, mg/L/	12.20	-
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/l/	0.78	<7.0
6	Кальци, (Ca ²⁺)мг/л /Calcium ion, mg/L/	10.42	<100.0
7	Магни (Mg ²⁺), мг/л /Magnesium ion, mg/L/	3.16	<30.0
8	Хлорид (Cl ⁻), мг/л /Chloride ion, mg/L/	4.25	<350.0
9	Хуурай үлдэгдэл, мг/л /TDS, mg/L/	52.0	<1000.0
10	Сульфат (SO ₄ ²⁻), мг/л /Sulfate ion, mg/L/	20.97	<500.0
11	Нитрат(NO ₃ ⁻), мг/л /Nitrate ion mg/L/	6.64	<50.0
12	Нитрит(NO ₂ ⁻), мг/л /Nitrite ion mg/L/	0.00	<1.0
13	Аммони, (NH ₄ ⁺) мг/л /Ammonia ion, mg/l/	0.13	<1.5
14	Төмөр (Fe ³⁺), мг/л /Total iron ion, mg/L/	0.04	<0.3
15	Натри+Кали (Na ⁺ ,K ⁺) /Sodium+Potassium ion, mg/L/	1.93	<200

Хүснэгт 7. Унд ахуйн гүний худгийн усны эрүүл ахуйн шинжилгээний үр дүн

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	Үр дүн	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS0900:2018
1	Нийт нянгийн тоо	0	<100
2	Гэдэсний бүлгийн савханцар /халуунд тэсвэртэй/ E.coli	Илрээгүй	Илрэхгүй
3	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч, бичил биетэн - Salmonella	Илрээгүй	Илрэхгүй
4	Сульфид задлагч, агааргүйтэн – Cl.perfringens	Илрээгүй	Илрэхгүй
5	Псевдомонас аерогиноза	Илрээгүй	Илрэхгүй

Цэвэрлэх байгууламжинд цэвэршүүлж буй бохир усны шинжилгээний үр дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024” стандартын ЗДХ-тэй харьцуулахад бохир усны хүнд металлын агууламж стандартын шаардлага хангаж байна. Харин химийн ерөнхий шинжилгээний үр дүнгээр Аммони, (NH₄⁺), Химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ), Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй гарсан байна (Хүснэгт 8, 9).

Хүснэгт 8. Цэвэрлэх байгууламжийн оролтын ус (бохир ус) – ны хүнд металлын шинжилгээ

№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн	№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн
1	Манган (Mn), мг/л	-	0.0003	14	Хөнгөнцагаан (Al), мг/л	<0.5	0.01
2	Никель (Ni), мг/л	<0.5	<0.005	15	Лити (Li), мг/л	-	<0.005
3	Зэс (Cu), мг/л	<1.0	<0.005	16	Бари (Ba), мг/л	-	<0.005
4	Кадми (Cd), мг/л	<0.05	<0.005	17	Мөнгө (Ag), мг/л	-	<0.005
5	Кобальт (Co), мг/л	<0.1	<0.005	18	Бор (B), мг/л	-	<0.005
6	Хар тугалга (Pb), мг/л	<0.2	<0.005	19	Галли (Ga), мг/л	-	<0.005
7	Цайр (Zn), мг/л	<5.0	<0.0031	20	Стронци (Sr), мг/л	-	<0.0251
8	Нийт төмөр (Fe), мг/л	, <3.0	<0.005	21	Талли (Tl), мг/л	-	<0.005
9	Бисмут (Bi), мг/л	-	<0.005	22	Уран (U), мг/л	-	<0.005
10	Молибден (Mo), мг/л	-	<0.005	23	Ванади (V), мг/л	-	<0.005
11	Рубиди (Rb), мг/л	-	<0.005	24	Биндер (Be), мг/л	-	<0.005
12	Теллур (Te), мг/л	-	<0.005	25	Нийт хром (Cr), мг/л	<1.0	<0.005
13	Селен (Se), мг/л	<0.1	<0.005	26	Хүнцэл (As), мг/л	<0.1	<0.005

Хүснэгт 9. Цэвэрлэх байгууламжийн оролтын ус (бохир ус) – ны химийн ерөнхий шинжилгээ

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	Үр дүн	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6561:2024
1	pH-Усан орчин /Hydrogen ions/	7.76	6.0-9.0
2	Аммони, (NH ₄ ⁺) мг/л /Ammonia ion, mg/l/	65.36	<20
3	Хлорид (Cl ⁻), мг/л /Chloride ion, mg/L/	248.15	<1000
4	Сульфат (SO ₄ ²⁻), мг/л /Sulfate ion, mg/L/	109.46	<700
5	Умбуур бодис, мг/л	210.00	<400
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ) мг/л	1505.00	<800
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ) мг/л	578.84	<400
8	Нитрит(NO ₂ ⁻), мг/л /Nitrite ion mg/L/	0.04	-

9	Нитрат(NO ₃ ⁻), мг/л /Nitrate ion mg/L/	0.53	-
---	--	------	---

Цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлсэн саарал усны шинжилгээний үр дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандарттай харьцуулахад саарал усны хүнд металлын агууламж стандартын шаардлага хангаж байна. Харин химийн ерөнхий шинжилгээний үр дүнгээр Химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ), Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй, гэдэсний бүлгийн савханцар илэрсэн байна (Хүснэгт 10, 11).

Хүснэгт 10. Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус (саарал ус) – ны хүнд металлын шинжилгээ

№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн	№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн
1	Манган (Mn), мг/л	<0.5	0.005	14	Хөнгөнцагаан (Al), мг/л	<0.5	0.0428
2	Никель (Ni), мг/л	<0.2	<0.005	15	Лити (Li), мг/л	-	<0.005
3	Зэс (Cu), мг/л	<1.0	<0.005	16	Бари (Ba), мг/л	<1.5	<0.005
4	Кадми (Cd), мг/л	<0.03	<0.005	17	Мөнгө (Ag), мг/л	-	<0.005
5	Кобальт (Co), мг/л	<0.02	<0.005	18	Бор (B), мг/л	<0.5	<0.005
6	Хар тугалга (Pb), мг/л	<0.1	<0.005	19	Галли (Ga), мг/л	-	<0.005
7	Цайр (Zn), мг/л	<3.0	<0.0146	20	Стронци (Sr), мг/л	<2.0	<0.0227
8	Нийт төмөр (Fe), мг/л	<1.0	<0.005	21	Талли (Tl), мг/л	-	<0.005
9	Бисмут (Bi), мг/л	-	<0.005	22	Уран (U), мг/л	<0.05	<0.005
10	Молибден (Mo), мг/л	<0.5	<0.005	23	Ванади (V), мг/л	<0.1	<0.005
11	Рубиди (Rb), мг/л	-	<0.005	24	Биндер (Be), мг/л	<0.001	<0.005
12	Теллур (Te), мг/л	-	<0.005	25	Нийт хром (Cr), мг/л	<0.3	<0.005
13	Селен (Se), мг/л	<0.02	<0.005	26	Хүнцэл (As), мг/л	<0.01	<0.005

Хүснэгт 11. Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус (саарал ус) – ны химийн ерөнхий шинжилгээ

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	Үр дүн	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS4943:2015
1	pH-Усан орчин /Hydrogen ions/	6.02	6.0-9.0
2	Аммони, (NH ₄ ⁺) мг/л /Ammonia ion, mg/l/	22.62	<20
3	Хлорид (Cl ⁻), мг/л /Chloride ion, mg/L/	131.16	<1000
4	Сульфат (SO ₄ ²⁻), мг/л /Sulfate ion, mg/L/	62.23	<700
5	Умбуур бодис, мг/л	13.0	<400
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ) мг/л	815.0	<800
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ) мг/л	313.46	<400
8	Нитрит(NO ₂ ⁻), мг/л /Nitrite ion mg/L/	0.03	-
9	Нитрат(NO ₃ ⁻), мг/л /Nitrate ion mg/L/	0.00	-
10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч	Илэрсэн	Илрэхгүй

5.3. Агаарын чанарын мониторинг

Цогцолборын орчны агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох хэмжилт судалгааг Байгаль орчны хэмжилзүйн төв лабораториор 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хийлгэсэн. Агаар дахь бохирдуулагч бодисуудын нэг удаагийн буюу 20 минутын дундаж хэмжилтийн үр дүнгээс үзэхэд нийт тоос, хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж болон дуу чимээний түвшин нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2025” -д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна (Лабораторийн шинжилгээний үр дүнг хавсаргав).

Хүснэгт 12. Агаарын чанарын шинжилгээний дүн

№	Хэмжилт хийсэн цэгүүд	Хүхэрлэг хий /SO ₂ /, мкг/м ³	Азотын давхар исэл /NO ₂ /, мкг/м ³	Нийт тоос /TSP/, мкг/м ³	Дуу чимээ, ДБА
1	Спорт аялал жуулчлалын цогцолбор	8	45	180	52
	MNS 4585:2025 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	450	200	500	60.0

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

ХАВСРАЛТ 1: ГҮНИЙ ХУДГУУДЫН ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

 СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН *Гүний хэдэв*
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ265623

.....-Д
Скай рэсорт
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа *LPLC-150* загварын *150* м³/ц
хэмжих хязгаартай, *150* мм-ийн голчтой № *202304424* -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *014* лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... *2027* оны *08* -р сарын *12* -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: *261124* м³

 Лабораторийн тэмдэг
2025 оны *08* -р сарын *12* -ны өдөр

 Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

 СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН *Гүний хэдэв*
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ244231

.....-Д
Sky resort
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа *Zemec-100* загварын *60* м³/ц
хэмжих хязгаартай, *100* мм-ийн голчтой № *16054338* -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *014* лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... *2027* оны *05* -р сарын *01* -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: *0122286* м³

 Лабораторийн тэмдэг
2025 оны *05* -р сарын *01* -ны өдөр

 Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

ХАВСРАЛТ 2: УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

оны -р сарын -ны
өдөр

Дугаар Е-2503-000286

Улаанбаатар хот Утас:

265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Скайрезорт ГХО-тай ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 5228697
Захирал: Батсуурь
Холбоо барих дугаар: 77000909
Факс :
И-мэйл хаяг :

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Скай Резорт цанын бааз, Маунт богд гольфын үйлчилгээ
Байршил: Улаанбаатар, Баянзүрх, 11-р хороо
Харьяалагдах сав газар: Түүл голын сав газар
Хамаарах салбар: Аялал жуулчлал
Төслийн дэлгэрэнгүй: Скай Резорт цанын бааз нь 2008 оноос аялал жуулчлалын салбарт 16 дахь жилдээ ажиллаж байна. Өвөлдөө цанын бааз, ресторан, бусад улиралд гольф, ресторан, хурим, эвентийн үйлчилгээ үзүүлдэг.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Скайрезорт

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
11	1 ээлжээр	31	90	12

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Цас хийх системд ашиглах усны хэмжээ	778.0	м3	Ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлтэд цас үйлдвэрлэх хоногийн хүчин чадлыг 778 м3 гэж тусгасан байна. Байгууллагаас ирүүлсэн төлөвлөгөөнд 50 хоног ажиллахаар төлөвлөсөн.

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	130.0	хоногт 1 хүн	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд ажилчдын тоог 130 байхаар дүгнэсэн.
Гольфийн талбайн усалгаа	300000.0	м2	БОННУ 32 дугаар хуудсанд 300,000 м2 талбай услахаар. Байгууллагын ирүүлсэн төлөвлөгөөнд 80 удаа услахаар батлуулж ирүүлсэн.
Бар зоогийн газар	798.0	таваг хоол	Боломжит нөөцийн дүгнэлтэд 798 үйлчлүүлэгч 365 хоног үйлчлүүлэхээр тусгасан.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Ахуйн хэрэгцээнд	17.5	1512.0	
Гүний худаг	Технологийн хэрэгцээнд	9.6	829.44	
Гүний худаг	Технологийн хэрэгцээнд	8.6	743.04	
Гүний худаг	Технологийн хэрэгцээнд	6.0	518.4	
Гүний худаг	Үнд ахуй	1.0	86.4	

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ:	Нью грийн ворлд ХХК
Холбоо барих:	89044866
Нэмэлт мэдээлэл:	2024 оны БОНБНҮнэлгээг шинээр батлуулсан

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
--------------------	------------------	-------------

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу Усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах.

11. Усны зарцуулалт

